221001	Их засвар	3,594,543,503.00	2,698,865,044.00
222001	Тоног төхөөрөмж	3,559,289,660.00	986,725,000.00
223001	Бусад хөрөнгө	6,877,764,846.00	7,856,497,228.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,779,405,111.00	3,730,150,541.00
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/		1,520,000.00
225105	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа /ТӨҮГ/		15,781,850.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-24,645,517,702.00</b>	<b>-24,063,162,992.00</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>-2,571,700,230.00</b>	<b>-1,929,019,089.68</b>
<b>14</b>	<b>Бусад эх үүсвэр</b>		<b>116,949,571.32</b>
145007	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		116,949,571.32
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>1,818,247,826.00</b>	<b>1,969,439,170.00</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	1,818,247,826.00	1,969,439,170.00
<b>25</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>753,452,404.00</b>	<b>76,529,491.00</b>
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөр төлсөн мөнгө		7,247,175.00
250005	Төлсөн ногдол ашиг	753,452,404.00	69,282,316.00
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>1,133,483,801.55</b>	<b>6,861,558,612.21</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,565,692,732.18	11,693,771,753.68
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,699,176,533.73	18,555,330,365.89

**2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	76,529,580,190.24	65,453,674,426.53	135,824,709,988.52	277,807,964,605.29
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,000,000.00	-449,922,598.60	1,610,393,441.72	1,161,470,843.12
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	76,530,580,190.24	65,003,751,827.93	137,435,103,430.24	278,969,435,448.41
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	3,530,377,522.35	863,732.71	3,531,241,255.06
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,892,786,240.43	52.00	19,650,699.57	1,912,436,992.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	-27,315,063.00	0.00	-10,057,194.85	-37,372,257.85
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	-800,000,000.00	-800,000,000.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	24,483,161,179.77	24,483,161,179.77
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	78,396,051,367.67	68,534,129,402.28	161,138,721,847.44	308,068,902,617.39
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	78,396,051,367.67	68,534,129,402.28	161,138,721,847.44	308,068,902,617.39
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	339,892,039.35	768,779,434.24	1,206,809,771.52	2,315,481,245.11
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	78,735,943,407.02	69,302,908,836.52	162,335,531,618.96	310,374,383,862.50
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-1,740,904,745.77	255,062,641.52	-1,485,842,104.25
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,214,845,400.00	0.00	0.00	1,214,845,400.00

**Өвөрхангай аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	628,521,477.00	0.00	0.00	628,521,477.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	32,663,367,538.02	32,663,367,538.02
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	80,579,310,284.02	67,562,148,186.50	195,261,340,098.50	343,402,798,569.02

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	ЗГСУМС гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>106,322,672,400.00</b>	<b>101,220,310,592.43</b>	<b>94,443,963,685.32</b>	<b>3,894,996,576.98</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>91,363,158,900.00</b>	<b>89,708,664,872.43</b>	<b>84,539,042,336.32</b>	<b>2,403,130,303.98</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>88,439,375,200.00</b>	<b>86,756,167,230.43</b>	<b>82,440,186,685.32</b>	<b>1,631,370,715.52</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>54,170,046,200.00</b>	<b>53,868,825,000.80</b>	<b>52,742,773,485.39</b>	<b>-847,870,032.14</b>
210101	Үндсэн цалин	39,344,308,800.00	38,898,452,926.96	37,808,949,458.05	-554,641,385.64
210102	Нэмэгдэл	10,819,540,500.00	11,100,369,513.26	11,068,385,746.26	-293,197,024.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	450,219,900.00	393,029,668.94	388,465,389.44	15,741,858.50
210104	Урамшуулал	2,967,406,400.00	2,982,536,663.11	2,982,536,663.11	-15,773,481.00
210105	Гэрээт ажлын хөлс	588,570,600.00	494,436,228.53	494,436,228.53	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>7,228,405,500.00</b>	<b>7,110,394,180.38</b>	<b>6,977,619,257.04</b>	<b>-122,883,106.70</b>
210201	Тэтгэврийн даатгал	5,202,697,500.00	5,009,694,634.62	4,941,013,671.28	-89,210,548.07
210202	Тэтгэмжийн даатгал	504,353,100.00	532,580,923.96	512,970,739.96	-8,693,302.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	407,215,500.00	423,055,410.59	413,445,611.59	-5,547,971.85
210204	Ажилгүйдлийн даатгал	101,285,800.00	113,987,838.35	102,935,782.35	-1,396,196.33
210205	Эрүүл мэндийн даатгал	1,012,853,600.00	1,031,075,372.86	1,007,253,451.86	-18,035,087.86
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>10,092,325,200.00</b>	<b>9,815,598,789.78</b>	<b>9,714,077,318.83</b>	<b>-163,545,697.05</b>
210301	Гэрэл, цахилгаан	831,977,800.00	708,196,751.53	690,941,129.58	-5,652,758.05
210302	Түлш, халаалт	8,593,447,900.00	8,503,791,231.25	8,426,873,076.25	-169,405,850.00
210303	Цэвэр, бохир ус	656,899,500.00	593,610,807.00	591,247,113.00	6,528,911.00
210304	Байрны түрээс	10,000,000.00	10,000,000.00	5,016,000.00	4,984,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,060,955,000.00</b>	<b>3,104,971,457.48</b>	<b>3,022,386,876.07</b>	<b>85,327,043.41</b>
210401	Бичиг хэрэг	197,985,200.00	221,857,458.53	199,918,868.53	14,123,330.00
210402	Тээвэр, шатахуун	1,000,308,600.00	1,020,340,847.50	1,005,691,967.50	25,013,380.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	264,535,100.00	245,084,425.45	237,043,717.04	3,999,491.41
210404	Ном, хэвлэл	83,153,200.00	79,808,256.00	76,718,916.00	2,789,540.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,058,909,500.00	1,049,688,713.00	1,047,648,713.00	1,682,604.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	456,063,400.00	488,191,757.00	455,364,694.00	37,718,698.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,351,854,800.00</b>	<b>3,390,680,074.05</b>	<b>2,777,265,551.05</b>	<b>534,275,590.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,098,602,100.00	1,231,344,876.00	643,897,953.00	537,571,308.00
210502	Хоол, хүнс	2,103,316,900.00	1,992,180,068.05	1,989,692,468.05	-21,050,346.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	149,935,800.00	167,155,130.00	143,675,130.00	17,754,628.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,836,948,500.00</b>	<b>1,841,203,476.00</b>	<b>1,764,382,490.00</b>	<b>49,897,972.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	645,145,900.00	633,164,920.00	633,164,920.00	11,904,150.00
210602	Тавилга	232,364,300.00	282,203,936.00	210,323,350.00	27,228,998.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,416,400.00	1,896,800.00	1,896,800.00	0.00
210604	Урсгал засвар	956,021,900.00	923,937,820.00	918,997,420.00	10,764,824.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>251,642,900.00</b>	<b>219,359,820.00</b>	<b>218,093,820.00</b>	<b>1,074,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	245,580,000.00	213,297,350.00	212,031,350.00	1,074,200.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	6,062,900.00	6,062,470.00	6,062,470.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>726,196,300.00</b>	<b>830,992,586.00</b>	<b>1,026,853,617.00</b>	<b>-265,470,400.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	631,062,400.00	757,014,162.00	955,200,725.00	-276,924,820.00

**Өвөрхангай аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

	үйлчилгээний төлбөр хураамж				
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	32,821,200.00	18,004,601.00	18,004,601.00	8,397,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	18,510,000.00	16,628,162.00	16,435,162.00	94,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	13,864,300.00	11,598,060.00	11,114,528.00	295,220.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	2,638,100.00	1,494,356.00	1,417,356.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,567,200.00	9,128,931.00	9,128,931.00	0.00
210807	Газрын төлбөр	17,455,500.00	16,846,714.00	15,274,714.00	2,635,200.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	277,600.00	277,600.00	277,600.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,721,000,800.00</b>	<b>6,574,141,845.94</b>	<b>4,196,734,269.94</b>	<b>2,360,565,146.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,396,035,700.00	6,256,548,333.00	4,086,750,459.00	2,145,781,191.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	324,965,100.00	317,593,512.94	317,593,512.94	7,174,253.00
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>285,287,400.00</b>	<b>283,917,400.00</b>	<b>170,907,300.00</b>	<b>35,500,000.00</b>
<b>2122</b>	<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	<b>285,287,400.00</b>	<b>283,917,400.00</b>	<b>170,907,300.00</b>	<b>35,500,000.00</b>
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	285,287,400.00	283,917,400.00	170,907,300.00	35,500,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,638,496,300.00</b>	<b>2,668,580,242.00</b>	<b>1,927,948,351.00</b>	<b>736,259,588.46</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>205,000,000.00</b>	<b>205,000,000.00</b>	<b>205,000,000.00</b>	<b>7,282,597.46</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	205,000,000.00	205,000,000.00	205,000,000.00	7,282,597.46
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,433,496,300.00</b>	<b>2,463,580,242.00</b>	<b>1,722,948,351.00</b>	<b>728,976,991.00</b>
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	153,163,700.00	153,121,500.00	8,400,000.00	144,721,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	714,238,400.00	687,114,415.00	173,913,024.00	624,801,391.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,185,391,700.00	1,169,896,857.00	1,169,896,857.00	-78,809,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	60,242,000.00	60,242,000.00	60,242,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	320,460,500.00	393,205,470.00	310,496,470.00	38,264,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>11,108,131,800.00</b>	<b>9,639,309,150.00</b>	<b>8,908,393,479.00</b>	<b>616,057,673.00</b>
220001	Барилга байгууламж	569,700,000.00	51,948,500.00	51,948,500.00	0.00
221001	Их засвар	723,421,000.00	721,674,610.00	121,349,841.00	600,324,769.00
222001	Тоног төхөөрөмж	15,000,000.00	15,000,000.00	15,000,000.00	0.00
223001	Бусад хөрөнгө	9,800,010,800.00	8,850,686,040.00	8,850,686,040.00	-114,857,998.00
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>3,851,381,700.00</b>	<b>1,872,336,570.00</b>	<b>996,527,870.00</b>	<b>875,808,600.00</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	3,851,381,700.00	1,872,336,570.00	1,872,336,570.00	-100.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>106,322,672,400.00</b>	<b>102,331,999,674.36</b>	<b>97,899,502,292.31</b>	<b>977,777,951.96</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>54,629,778,200.00</b>	<b>54,335,231,245.74</b>	<b>82,299,291,424.09</b>	<b>30,296,259,703.47</b>
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	54,629,778,200.00	54,335,231,245.74	53,421,822,176.59	-1,944,850,505.97
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>40,199,861,000.00</b>	<b>41,037,425,741.50</b>	<b>7,645,636,329.00</b>	<b>32,899,022,164.52</b>
320001	Орон нутгийн төсвөөс	32,488,671,100.00	33,286,235,812.50	0.00	32,662,008,564.52
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	7,711,189,900.00	7,751,189,929.00	7,751,189,929.00	131,460,000.00
<b>33</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>725,414,200.00</b>	<b>1,350,409,610.00</b>	<b>682,169,002.00</b>	<b>117,823,833.00</b>
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		668,240,608.00	0.00	179,303,973.00
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	725,414,200.00	682,169,002.00	682,169,002.00	-61,480,140.00
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>10,767,619,000.00</b>	<b>5,608,933,077.12</b>	<b>7,272,405,537.22</b>	<b>-1,770,757,242.09</b>

Өвөрхангай аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,476,161,000.00	3,345,879,420.16	3,331,318,373.42	-50,460,185.25
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,148,943,500.00	759,054,156.96	763,782,656.96	38,835,569.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	6,142,514,500.00	1,503,999,500.00	5,148,348,229.13	-3,730,176,348.13
<b>36</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>		<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>27,948,900.00</b>
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих		0.00	0.00	27,948,900.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,299,953,422.08	0.00	2,251,934,466.52
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		3,413,115,504.01	0.00	33,209,811,473.24
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>40,844.00</b>	<b>5,725,427.00</b>	<b>0.00</b>	<b>8,376,069.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>175.00</b>	<b>167.00</b>	<b>0.00</b>	<b>164.00</b>
610001	Төсвийн байгууллага	166.00	166.00	0.00	163.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	9.00	1.00	0.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГАСДЫН ТОО</b>	<b>4,322.50</b>	<b>261,152.00</b>	<b>0.00</b>	<b>399,930.00</b>
620001	Удирдах ажилтан	327.00	329.00	0.00	326.00
620002	Гүйцэтгэх ажилтан	2,770.50	208,644.00	0.00	323,478.00
620003	Үйлчлэх ажилтан	1,176.00	52,129.00	0.00	76,076.00
620004	Гэрээт ажилтан	49.00	50.00	0.00	50.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>32,024.00</b>	<b>5,193,594.00</b>	<b>0.00</b>	<b>7,566,683.00</b>
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	<b>23,309.00</b>	<b>4,411,256.00</b>	<b>0.00</b>	<b>6,784,642.00</b>
630001	Төрийн өмчит ЕБС	23,309.00	4,411,256.00	0.00	6,784,642.00
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	<b>8,715.00</b>	<b>782,338.00</b>	<b>0.00</b>	<b>782,041.00</b>
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	8,715.00	782,338.00	0.00	782,041.00
<b>64</b>	<b>ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО</b>	<b>1.00</b>	<b>9,362.00</b>	<b>0.00</b>	<b>9,362.00</b>
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо		789.00	0.00	789.00
640002	Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо		8,573.00	0.00	8,573.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>4,322.50</b>	<b>261,152.00</b>	<b>0.00</b>	<b>399,930.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	343.00	341.00	0.00	341.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	3.00	3.00	0.00	3.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	45.00	161.00	0.00	161.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	124.00	130.00	0.00	130.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	342.00	342.00	0.00	342.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3,205.50	259,911.00	0.00	398,689.00
650010	Гэрээт ажилтан	88.00	91.00	0.00	91.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	172.00	173.00	0.00	173.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Код	Үзүүлэлт	ТЕЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>11,445,536,186.47</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>11,006,994,186.47</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>9,671,909,549.72</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,655,051,380.99</b>
210101	Үндсэн цалин	1,061,776,430.68
210102	Нэмэгдэл	354,322,231.01
210103	Унаа хоолны хөнгөлөлт	58,585,500.00
210104	Урамшуулал	138,956,011.00
210105	Гэрээт ажлын хөлс	41,411,208.30
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>204,483,226.82</b>
210201	Тэтгэврийн даатгал	172,941,388.81

Өвөрхангай аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210202	Тэтгэмжийн даатгал	7,765,689.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,479,636.06
210204	Ажилгүйдлийн даатгал	1,510,224.64
210205	Эрүүл мэндийн даатгал	14,786,287.63
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>126,828,107.99</b>
210301	Гэрэл, цахилгаан	78,230,841.99
210302	Түлш, халаалт	18,651,448.00
210303	Цэвэр, бохир ус	29,945,818.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>905,971,557.90</b>
210401	Бичиг хэрэг	33,851,757.00
210402	Тээвэр, шатахуун	221,234,570.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,018,765.90
210404	Ном, хэвлэл	20,763,050.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	496,145,159.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	127,958,256.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,673,387,118.85</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,473,633,417.35
210502	Хоол, хүнс	163,751,855.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	36,001,846.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>449,257,845.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	112,906,819.00
210602	Тавилга	23,917,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	24,612,500.00
210604	Урсгал засвар	287,821,526.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>15,635,876.00</b>
210702	Дотоод албан томилолт	15,635,876.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,071,393,591.54</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,054,268,601.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,166,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,533,645.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,682,438.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	528,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	108,000.00
210807	Газрын төлбөр	8,584,348.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	522,159.54
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,569,900,844.63</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,482,597,089.63
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	87,303,755.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,335,084,636.75</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>810,684,779.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	533,964,000.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	150,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,417,639.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	267,153,140.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>524,399,857.75</b>
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	288.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	94,884,303.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	3,061,888.17
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	912,000.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	425,541,378.58
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>438,542,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>438,542,000.00</b>
222001	Тоног төхөөрөмж	2,535,000.00
223001	Бусад хөрөнгө	338,990,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	97,017,000.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>11,445,626,186.86</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>11,445,626,186.86</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	38,227,400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,660,245,115.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,351,352,837.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,395,800,834.86
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>90,000.39</b>
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	90,000.39

### 3.Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өвөрхангай аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022.04.08-аас 2022.04.20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022.04.20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг, аудитор Ц.Мөнхзаяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.04.01-ний өдрийн 01/168 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд “Аймгийн эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хадгалж, иргэдийн орон нутагтаа ажиллаж, амьдрах таатай орчинг бүрдүүлэн, байгаль орчин, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, бие даасан, оновчтой хөгжлийн загвар бүхий эдийн засагтай болоход оршино” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлжээ.

Өвөрхангай аймаг 2021 оныг “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих” жил болгон зарласан.

2021 оны аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд:

- Хүний хөгжил бүлгийн 7 зорилтын хүрээнд 93 арга хэмжээ
- Эдийн засаг бүлгийн 4 зорилтын хүрээнд 51 арга хэмжээ
- Засаглалын бодлого бүлгийн 6 зорилтын хүрээнд 30 арга хэмжээ

Нийт 3 бүлэг 17 зорилтын хүрээнд 174 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын албанаас 2021 онд дараах чиглэлүүдээр аудит хийсэн байна.

Тайлант хугацаанд хууль тогтоомж, төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдүүлэхээр тогтоосон дүрэм, журам, норм, стандартын биелэлтийг 23 төсөвт байгууллагад хийсний 21 нь төлөвлөгөөт, 2 төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийжээ. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 199 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд санхүүгийн хяналт шалгалтыг хийжээ.

Дотоод аудитын чиглэлээр 4 ажил гүйцэтгэсэн байна..

Санхүүгийн хяналт шалгалтаар нийт 1,581.9 сая төгрөгийн 8 төрлийн зөрчлийг илрүүлж, шалгалтын хугацаанд 125.6 сая төгрөгийн зөрчлийг арилгуулан, зөрчлийг засаж залруулах 109 заалттай, тухайн байгууллагад төвлөрүүлэх 944.4 сая төгрөг бүхий 23 албан шаардлага, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх 8.1 сая төгрөг, тухайн байгууллагад төвлөрүүлэх 0.7 сая төгрөг, нийт 8.8 сая төгрөгийн 10 акт тогтоосон.

Хяналт шалгалтаар тогтоосон актын биелэлт 100 хувьтай, албан шаардлагын биелэлт 12 хувьтай, 88 хувь нь хугацаа болоогүй байна.

Дотоод аудитаар нийт 14 төрлийн асуудлыг илрүүлж нийт 127 заалт бүхий зөвлөмж өгсөн зөвлөмжийн биелэлт 16% тай байгаа ба 77%-ийн биелэлтийг тооцох хугацаа болоогүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 269,286.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 2,692.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,019.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж гүйцэтгэлийн шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	өсөлт + бууралт -	Эзлэх хувь
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>11699.2</b>	<b>18560.7</b>	<b>6861.5</b>	<b>100</b>
<b>31100</b>	<b>Касст байгаа бэлэн мөнгө</b>	<b>38.6</b>	<b>20.9</b>	<b>-17.7</b>	<b>0.1</b>
<b>31211</b>	<b>Төрийн сангийн харилцах</b>	<b>9018.9</b>	<b>15009</b>	<b>5990.1</b>	<b>80.9</b>
<b>31213</b>	<b>Арилжааны банк дахь харилцах</b>	<b>2641.7</b>	<b>3530.8</b>	<b>889.1</b>	<b>19.0</b>

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 6,861.5 сая төгрөгөөр өссөн байна.

Төрийн сангийн харилцах дансны мөнгөн хөрөнгө нь дараах байгууллагуудад үлдэгдлээр байна.

сая төгрөгөөр

Өвөрхангай аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудит



Created with Datawrapper

Арилжааны банкин дахь харилцах дансны үлдэгдэл



Created with Datawrapper

Төрийн өмчийн аж ахуй нэгж байгууллагууд 20.9 сая төгрөгийн кассын үлдэгдэлтэй гарсан байна.

Аудитын илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгөтэй холбоотой нийт **1,671.8** сая төгрөгийн зөрчил илэрснээс зарим материаллаг дүнтэй зөрчлөөс дурдвал:

-Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар зарцуулсан, ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн 29.5 сая төгрөг / Тухайлбал: ХГБХХэлтэс 2.4 сая, Нарийнтээл сумын ЗДТГ 9.0 сая, Гучин-Ус сумын ЗДТГ 3.9 сая, Бүрд сумын ЗДТГ 1.0 сая, Тарагт сумын Туяа бага сургууль 9.9 сая, Тарагт сумын Соёлын төв 2.0 сая төгрөг/

-Мөнгөн хөрөнгийн хяналт хангалтгүй, Хөрөнгийн тооллогын бүртгэл хангалтгүй 2.5 сая сая төгрөгийн зөрчил Арвайхээр нийтийн тээвэр гэрэлтүүлэг ОНӨААТҮГ-т илэрсэн

-Арвайхээр тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авсан гэрээгээр 66.5 сая төгрөгийн ажил үйлчилгээ үзүүлэх байтал уг ажлыг өөр байгууллагаар гүйцэтгүүлсэн.

-Цалин урамшуулал, ХХОАТ, НДШ илүү дутуу олгосон 5.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

-Мөнгөн гүйлгээний тайлагнал, бэлэн мөнгөний тайлан гаргалттай холбоотой 116.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн./Аймгийн ТЕЗ-ын нэгтгэсэн тайланд 74.6 сая,Хужирт сумын 1-р цэцэрлэгт 10.6 сая, 3-р цэцэрлэгт 11.2 сая төгрөг/

-Баянтээг ХК тэтгэмж, урамшууллын зардлаас: Аймаг, сум, орон нутгийн нэрийг алдаршуулж буй спортын тамирчинд 10.0 сая төгрөг, байгууллагуудын түүхт 100 жилийн ойн зориулан 11.5 сая төгрөг, Бөхийн холбоонд 3.2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Компани нь нийгмийн өмнөх хариуцлагын хүрээнд нийт цэвэр ашгийн 10 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөр хөрөнгө оруулалтын ажил хийх эрхтэй боловч 10.0 хувиас хэтрүүлэн 2021 онд 1.0 тэрбум төгрөгийг төлөвлөж, зарцуулсан гэх мэт.

-ЗГ-ын 43 дугаар тогтоолыг зөрчсөн 424.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /БОАЖГ 5.8 сая төгрөг, Эрдэнэзуу музей 8.9 сая төгрөг, Уянга сумын Соёлын төв 17.1 сая төгрөг, Хархорин сумын СТ 1.7 сая төгрөг, Баянгол сумын цэцэрлэг 2.1 сая төгрөг, ХДТ 2.4 сая төгрөг, Уянга сумын 1-р цэцэрлэг 2.1 сая төгрөг, Арвайхээр сумын 6-р цэцэрлэг 3.6 сая төгрөг, 5-р цэцэрлэг 1.6 сая төгрөг, 2-р цэцэрлэг 8.1 сая төгрөг, 1-р цэцэрлэг 5.4 сая төгрөг, Хужирт сумын 2-р цэцэрлэг 3.3 сая төгрөг, 1-р цэцэрлэг 1.9 сая төгрөг, Баянгол сумын ЕБС 13.1 сая төгрөг, Есөнзүйл сумын ЕБС 6.0 сая төгрөг, Тэмүүлэл-Эрдэм сургууль 3.4 сая төгрөг, Арвайхээр сумын 5-р сургууль 3.8 сая төгрөг, 2-р сургууль 3.1 сая төгрөг, Хужирт сумын ЕБС 1.5 сая төгрөг, Нарийнтээл сумын ЗДТГ 46.5 сая төгрөг, Хархорин сумын ЗДТГ 7.4 сая төгрөг, Уянга сумын ЗДТГ 5.8 сая төгрөг, Өлзийт сумын ЗДТГ 4.6 сая төгрөг, Сант сумын ЗДТГ 5.2 сая төгрөг, Бат-Өлзий сумын ЗДТГ 3.0 сая төгрөг, Есөнзүйл сумын ЗДТГ 2.5 сая төгрөг, Гучин-Ус сумын ЗДТГ 55.0 сая төгрөг, Төгрөг сумын ЗДТГ 9.8 сая төгрөг, Аймгийн ЗДТГ 150.4 сая төгрөг, Арвайхээр сумын ИТХ 3.5 сая төгрөг, Хужирт сумын ИТХ 5.6 сая төгрөг, Хайрхандулаан сумын ИТХ 4.5 сая төгрөг, Аймгийн ИТХ 3.0 сая төгрөг....г.м/

### 3.5.2 Авлага

Авлага өмнөх оноос 957.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	өсөлт + бvvралт -	Эзлэх хувь
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>8719.4</b>	<b>9677.3</b>	<b>957.9</b>	<b>100</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	59.5	372.1	312.6	3.8
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	7.8	413.2	405.4	4.3
33300	Татаас, санхүүжилтийн авлага	67.2	880.3	813.1	9.1
33400	Зээлийн хүүгийн авлага	179.4	133.5	-45.9	1.4
33401	Дансны авлага /ТӨҮГ/	1235.5	1310.2	74.7	13.5
33402	Татвар НДШ-ийн авлага /ТӨҮГ/	30.6	5.6	-25	0.1
33510	Байгууллагаас авах авлага	594.4	1232.1	637.7	12.7
33520	Хувь хүмүүсээс авах авлага	6362.5	5185.3	-1177.2	53.6
33600	Зээлийн авлага	182.5	145	-37.5	1.5

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 53.6 хувийг хувь хүмүүсээс авах авлага эзэлж байна. Энэ нь 19 сумын ОНХСан, эрсдэлээс хамгаалах сан, сум хөгжүүлэх сангаас олгосон зээл, малжуулах төсөл болон өвс тэжээлийн авлага байна.

Дансны авлага нийт авлагын 13.5 хувийг эзэлж байна. Энэхүү авлагын 1,292.7 сая төгрөг нь Баянтээг ХК-ний, 16.6 сая төгрөг нь ӨВ-ЭКО Мийт ОНӨААН-ийн, 0.4 сая төгрөг нь Баянтээг түлш ОНӨААН-ийн авлага тус тус байна.

Байгууллагаас авах авлага нийт авлагын 12.7 хувийг эзэлж байна. Үүний 251.4 сая төгрөг нь Онги-Ус суваг ОНӨААТҮГ-ийн авлага гол нөлөө үзүүлж байна.

Баянтээг ХК, Өв эко мийт ХХК-иудын борлуулалтын болон татвар, ндш-ийн авлага 1,266.1 сая төгрөг байна. Мөн ӨВ-Агро ОНӨААН 61.8 сая төгрөг, Хархорин Ус суваг компани 56.6 сая төгрөгийн байгууллагаас авах авлагатай гарчээ.

Татаас санхүүжилтийн авлага 813.1 сая төгрөгөөр өссөн нь Сумдын эрүүл мэндийн төвүүдийн санхүүжилт дутуу орж ирснээс шалтгаалж ЭМД-ын сангаас авлагатай гарчээ.

Авлагын данстай холбоотой **879.1** сая төгрөгийн зөрчил илэрснээс зарим материаллаг дүнтэй зөрчлөөс дурдвал:

Өвөрхангай аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

-Авлага бүртгэгдсэн боловч тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, хаанаас авлагатай болохыг тодруулга тайланд тодруулаагүй 198.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Баянтээг ХК 184.1 сая төгрөг, Онги-Ус суваг ОНӨААТҮГ 5.6 сая төгрөг/

-Авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй нийт 665.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Өлзийт сумын СХСанд 113.8 сая төгрөг, Хархорин сумын СХСанд 507.0 сая төгрөг, Гучин-Ус сумын ОНХСанд 28.8 сая төгрөг, Есөнзүйл сумын ОНХСанд 10.0 сая төгрөг гэх мэт.../

-Хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулаагүй 6.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. /Өлзийт сумын Соёлын төвд 0.8 сая төгрөг, Хархорин ӨЭМТөвд 0.7 сая төгрөг, Богд сумын ЕБС-д 4.7 сая төгрөг/

-Эзэн холбогдогчгүй 8.8 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд үлдэгдлээр тусгасан. /Уянга сумын СХСан/

### 3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данс тайлант онд 746.9 сая төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт №3 Урьдчилгааны үлдэгдэл /сая төгрөг/**

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	өсөлт + бууралт -	Эзлэх хувь
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>105.4</b>	<b>852.3</b>	<b>746.9</b>	<b>100</b>
34600	Урьдчилж гарсан зардал	104.5	851	746.5	99.8
34713	Цалингийн урьдчилгаа	0.9	1.2	0.3	0.1

*Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Урьдчилж гарсан зардалд Аймгийн ОНХСан 580.0 сая төгрөг, ОНХО-ын данс 111.0 сая төгрөг, Аймгийн ЗДТГазар 94.8 сая төгрөг, Засаг дарга данс 37.1 сая төгрөгийг бүртгэсэн байна.

Баруунбаян-Улаан сумын ОНХСан тухайн ондоо багтааж хөрөнгө оруулалтын ажил нь дуусгаагүй, 17.5 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилтээ хөрөнгийн зардалд бичсэн байсныг урьдчилгаа дансанд бүртгүүлсэн.

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 5,382.8 сая төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/**

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	өсөлт + бууралт -	Эзлэх хувь
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>18427.4</b>	<b>23810.2</b>	<b>5382.8</b>	<b>100</b>
35100	Түүхий эд материал	1513.6	2704.3	1190.7	11.4
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	10880.6	13929.6	3049	58.5
35300	Бэлэн бүтээгдэхүүн	293	280.6	-12.4	1.2
35400	Хангамжийн материал	5544.2	6696.4	1152.2	28.1
35500	Биологийн хөрөнгө	21.6	26.5	4.9	0.1
35600	Мал амьтад	174.4	172.8	-1.6	0.7
36	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	<b>421.4</b>	<b>371</b>	<b>-50.4</b>	<b>100.0</b>
36300	Тэжээлийн нөөц	80.7	61.3	-19.4	16.5
36500	Буудайн нөөц	0	23.4	23.4	6.3
36600	Бусад нөөц	340.7	286.3	-54.4	77.2

*Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд бараа материалын үлдэгдэл нэмэгдсэн гол шалтгаан нь Улсын болон

орон нутгийн хөрөнгө оруулалтаар баригдаж, тухайн ондоо дуусаагүй, 2022 онд ашиглалтад орох 13,929.6 сая төгрөгийн барилга байгууламжуудыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэсэнтэй холбоотой байна. Энэ нь нийт үлдэгдлийн 58.5 хувийг эзэлж байна.

Тайлант онд хангамжийн материал дансны үлдэгдэл 1,152.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Баянтээг ХК, Аймгийн ЗДТГазар, ӨВ-ЭКО Мийт ОНӨААТҮГ зэрэг байгууллагуудад материал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Түүхий эд материалын данс 1,190.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь цар тахалтай холбоотой ЭМ-ийн байгууллагуудад тусгай зориулалтын материал, эм боох материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

*Бараа материалын данстай холбоотой 5,081.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс зарим материаллаг дүнтэй зөрчлөөс дурдвал:*

*-Бараа материалын тайлангийн орлого зарлагын анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй, шаардах хуудас, замын хуудас зэргийг хөтлөөгүй, гарын үсгийн бүрдэл дутуу зэрэг 21.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Тарагт сумын ЗДТГ 0,1 сая төгрөг, Арвайхээр сумын ЗДТГ 8.7 сая төгрөг, Баянгол сумын ИТХ 6.2 сая төгрөг, Тарагт сумын ИТХ 0.4 сая төгрөг, Зүүнбаян-Улаан сумын ИТХ 6.2 сая төгрөг /*

*-Бараа материалын тооллогыг хуулийн дагуу хийгээгүй, дутуу, чанаргүй хийсэнтэй холбоотой 39.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн /Төгрөг сумын ИТХ 0.7 сая төгрөг, Хайрхандулаан сумын ИТХ 3.1 сая төгрөг, Хархорин сумын 3-р сургууль 3.6 сая төгрөг, Богд сумын СХСан 0.4 сая төгрөг, Нарийнтээл сумын Баянтээг багийн цэцэрлэг 6.1 сая төгрөг, Арвайхээр сумын 5-р цэцэрлэг 1.6 сая төгрөг, Бүрд сумын цэцэрлэг 22.4 сая төгрөг, Баянгол сумын ЕБС 1.4 сая төгрөг/*

*-Бараа материалыг буруу ангилалд бүртгэсэн, бараа материалын тайлан гаргаагүй, шууд зардалд бичилт хийсэн зэрэг нийт 37.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Хархорин сумын ЗДТГ 2.3 сая төгрөг, Есөнзүйл сумын ЭМТөв 6.3 сая төгрөг, Нарийнтээл сумын ЭМТ 1.8 сая төгрөг, ЗБУ сумын соёлын төв 2.5 сая төгрөг, ОНӨХ 1.9 сая төгрөг, гэх мэт/*

*-Бараа материал дуусаагүй үйлдвэрлэлийг данс бүртгэлд тусгаагүй 4,976.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Аймгийн ЗДТГ-т 4,974.7 сая төгрөг, Тарагт сумын ИТХ 0.1 сая, Баян-Өндөр сумын ИТХ 0.7 сая төгрөг, ЗБУ сумын ИТХ 0.8 сая төгрөг/*

*-Хүнсний материалыг дутагдуулсан 6.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Есөнзүйл сумын цэцэрлэг 4.4 сая төгрөг, Арвайхээр сумын 5-р цэцэрлэг 2.4 сая төгрөг/*

### 3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө 24,273.4 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	өсөлт + бууралт -	Эзлэх хувь
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	271323	295596.4	24273.4	100
39100	Газар	0.8	0	-0.8	
39200	Биет хөрөнгө	258834.6	280488.4	21653.8	94.9
39300	Биет бус хөрөнгө	12487.7	14296.5	1808.8	4.8
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0	811.6	811.6	0.3

*Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 3,730.2 сая төгрөг, үнэ төлбөргүй болон шилжүүлэн авсан 53,245.4 сая төгрөгөөр нэмэгдэж, 5,537.9 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн, 3,683.5 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан, 351.0 сая төгрөгийн хөрөнгийг худалдсан, 1,260.1 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлэхээр данснаас

хассан байна. Тайлант хугацаанд 27,997.6 сая төгрөгийн элэгдэл тооцож зардалд бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгөтэй холбоотой **3,007.4** сая төгрөгийн зөрчил илэрснээс зарим материаллаг дүнтэй зөрчлөөс дурдвал:

-Үндсэн хөрөнгийн бүртгэл, тодруулга тайлангийн уялдаа, хөрөнгийн тайлагналтай холбоотой 344.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Бат-Өлзий сумын Соёлын төв 15.2 сая төгрөг, Богд сумын Соёлын төв 18.6 сая төгрөг, Төгрөг сумын Соёлын төв 17.5 сая төгрөг, Бүрд сумын Соёлын төв 22.8 сая төгрөг, Тарагт сумын ЭМТ 20.2 сая төгрөг, Арвайхээр сумын 6-р цэцэрлэг 29.4 сая төгрөг, Бүрд сумын ЕБС 166.2 сая төгрөг, Бат-Өлзий сумын ЗДТГ 44.2 сая төгрөг /

- Үндсэн хөрөнгийн тооллогыг хуулийн дагуу хийгээгүй, дутуу, чанаргүй хийсэнтэй холбоотой 2,111.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /ТҮНТөв 24.5 сая төгрөг, Нарийнтээл сумын Соёлын төв 505.3 сая төгрөг, Богд сумын СТөв 10.2 сая төгрөг, Төгрөг сумын СТөв 12.8 сая төгрөг, Бүрд сумын СТөв 1398.2 сая төгрөг, Хужирт сумын ЭМТ 116.3 сая төгрөг г.м/

-Үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй 430.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Уянга сумын 2-р сургууль 195.4 сая төгрөг, Хархорин сумын ЗДТГ 112.0 сая төгрөг, Аймгийн ЗДТГазар 117.5 сая төгрөг г.м /

-Үндсэн хөрөнгө олж бэлтгэхдээ худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй 52.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Хархорин сумын Номын хүрдэн сургууль/

-Хөрөнгө нь тухайн байгууллагад биетээр оршин байхгүй 30.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Есөнзүйл сумын ИТХ/

### 3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн үлдэгдэл 2,838.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	өсөлт + бууралт -
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<b>24922.3</b>	<b>27760.5</b>	<b>2838.2</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1855.5	4693.7	2838.2
41300	Өглөг	1855.4	3965.6	2110.2
41360	Урьдчилж орсон орлого	0.1	728.1	728
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	23066.8	23066.8	0
42214	Төрийн өмчит ААН-н зээл	771.4	771.4	0
42222	ОУ-ын санхүүгийн байгууллагаас	22295.4	22295.4	0

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөр өссөн нь Эрүүл мэндийн байгууллагууд ЭМД-аас авах санхүүжилтийн авлагатай гарсантай холбоотой ажилчидтай холбогдсон өглөг 968.6 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлын өглөг 388.6 сая төгрөгөөр, байгууллагад төлөх өглөг 544.1 сая төгрөгөөр өссөн байна.

Баянтээг ХК 309.4 сая төгрөг, Онги-Ус суваг 39.1 сая төгрөг, Хархорин ус суваг 11.6 сая төгрөг, ӨВ-ЭКО мийт 5.7 сая төгрөг, Баянтээг түлш компани 3.2 сая төгрөгийн татварын өртэй гарчээ.

Урьдчилж орсон орлого дансанд 728.1 сая төгрөгийг бүртгэжээ. Энэ нь техник хяналтын барьцаа дансанд ОНХСан, ОНХО-аар хийгдээд дуусаагүй байгаа ажлуудын санхүүжилтийн дутууг төвлөрүүлж бүртгэсэн байна.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Хот байгуулалтын салбар МОН-2301 төсөл”, Зүүн өмнөд говийн хот байгуулалт хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3388 төсөл”-ийн хүрээнд 2020 онд тайланд тусгасан 22 тэрбум 295.4 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрөөс тайлант онд төлөгдөөгүй байна.

Өр төлбөр данстай холбоотой **51.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн.**

-Өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 25.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Нарийнтээл сумын ЭМТ 1.9 сая төгрөг, Бат-Өлзий сумын ЗДТГ 20.4 сая төгрөг Бат-Өлзий сумын ИТХ 3.3 сая төгрөг /

-Өр төлбөрийг тайлан бүртгэлд тусгаагүй нийт 25.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн./Аймгийн ЗДТГ 0.6 сая төгрөг, Уянга сумын 2-р сургууль 5.1 сая төгрөг, Есөнзүйл сумын ЭМТөв 18.0 сая төгрөг, Бүрд сумын СХСан 1.1 сая төгрөг /

-Өр төлбөрийн дансны бичилт тайлагналтай холбоотой 0.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн./Баян-Өндөр сумын ЕБС /

### 3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 35,333.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Засгийн газрын оролцоо /сая төгрөг/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	өсөлт + бүүралт -	Эзлэх хувь
51	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО	<b>308068.9</b>	<b>343402.8</b>	<b>35333.9</b>	<b>100</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	72940.3	75098.9	2158.6	21.9
51101	Өмч /төрийн/ ТӨҮГ	4843.1	4867.7	24.6	1.4
51102	Өмч /хувьцаат/ ТӨҮГ	7.6	7.6	0	0.0
51106	Эздийн өмчийн бусад хэсэг ТӨҮГ	605.2	605.2	0	0.2
51200	Хуримтлагдсан үр дүн	161138.7	195261.3	34122.6	56.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	68534.1	67562.1	-972	19.7

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн засгийн газрын сан 2,158.6 сая төгрөгөөр өссөн нь шинээр байгуулагдсан ӨВ-Агро, Баянтээг түлш зэрэг ОНӨААНэгжүүд, Есөнзүйл сумын ЭМТөв, ТЕЗ-ийн тайланд нэгтгэгдсэнтэй холбоотой байна. Мөн тайлант онд Орон нутгийн өмчийн газар 415.6 сая төгрөгөөр, Мэргэд сургууль 65.6 сая төгрөгөөр, Арвайхээр сум 1,405.0 сая төгрөгөөр, Төгрөг сум 518.0 сая төгрөгөөр, Уянга сум 16.3 сая төгрөгөөр тус тус газар шинээр бүртгэлд тусгажээ.

Хуримтлагдсан үр дүн 34,122.6 сая төгрөгөөр өссөн нь үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хөрөнгийн орлого нэмэгдсэнтэй холбоотой өссөн байна.

Аудитын илрүүлэлт: Хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой **2,376.8 сая төгрөгийн алдаа илэрсэн.**

Баянтээг ХК нь 2,376.8 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгөдөө дахин үнэлгээ хийлгээгүй зөрчил илэрсэн. Мөн Арвайхээр сумын 2-р цэцэрлэгийн тайланд Өмнөх оны хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 10.3 сая төгрөгөөр зөрүүтэй татагдсан.

### 3.5.8 Орлогын данс

Өвөрхангай аймгийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар 324,845.1 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого тайлагнасан.

Орлогын данстай холбоотой **124.8** сая төгрөгийн зөрчил илэрснээс зарим материаллаг дүнтэй зөрчлөөс дурдвал:

-Үнэ төлбөргүй хөрөнгийн орлогыг буруу бүртгэсэн болон орлого тайлагналтай холбоотой 33.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн. / Бүрд сумын СХСан 7.3 сая төгрөг, Баянгол сумын цэцэрлэг 9.0 сая төгрөг, Хархорин сумын 3-р сургууль 15.6 сая төгрөг, Хархорин сумын ЗДТГ 1.3 сая төгрөг /

-ТЕЗ-ийн санхүүгийн тайланд үйл ажиллагааны орлого болон нэмэлт санхүүжилтийн орлогыг бүртгэл тайланд дутуу бүртгэсэнтэй холбоотой 91.6 сая төгрөгийн алдаа илэрсэн./Богд ЭМТ 10.9 сая төгрөг, Нарны дөш ӨЭМТ 43.3 сая төгрөг, Түшиг дөлгөөн ӨЭМТ 29.7 сая төгрөг, ББУ ЭМТ 7.4 сая төгрөг/

### 3.5.9 Зардлын данс

Өвөрхангай аймгийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар 269,286.5 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал, 22,895.2 сая төгрөгийн үйл ажиллагааны бус зардал, нийт 292,181.7 сая төгрөгийн зардал тайлагнасан.

Зардлын данстай холбоотой **890.2** сая төгрөгийн зөрчил илэрснээс зарим материаллаг дүнтэй зөрчлөөс дурдвал:

-Урсгал үйл ажиллагааны зардлыг илүү дутуу тайлагнасан нийт 146.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /ТЕЗ-ийн тайланд 28.7 сая төгрөг, БТСГ 6.0 сая төгрөг, ХДТ 4.1 сая төгрөг, Уян сэтгэл ӨЭМТ 3.8 сая төгрөг, Хужирт сумын ЭМТ 5.0 сая төгрөг, Уянга сумын 1-р цэцэрлэг 7.8 сая төгрөг, ББУ сумын цэцэрлэг 11.3 сая төгрөг, Уянга сумын 2-р сургууль 21.6 сая төгрөг, Бат-Өлзий сумын ЗДТГ 21.6 сая төгрөг, Өлзийт сумын ЗДТГ 7.7 сая төгрөг ...г.м /

-Батлагдсан зардлыг зориулалт бус зарцуулсан 41.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Арвайхээр ТҮК 6.4 сая төгрөг, Уянга сумын ЭМТ 2.2 сая төгрөг, ББУ сумын ЭМТ 2.4 сая төгрөг, Арвайхээр 10-р цэцэрлэг 1.7 сая төгрөг, Арвайхээр сумын 14-р цэцэрлэг 2.7 сая төгрөг, Уянга сумын 2-р цэцэрлэг 3.5 сая төгрөг, Хужирт сумын 1-р цэцэрлэг 5.2 сая төгрөг, ББУ сумын ЕБС 4.2 сая төгрөг, Хужирт сумын ЕБС 3.0 сая төгрөг, Хайрхандулаан сумын ИТХ 2.0 сая төгрөг...г м/

